



САР ХАРИУЦСАН АЛБА, ТАСАГ НЭГЖИЙН 2026 ОНЫ 5-Р САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026.06.05

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хувь
1	<p>“Цэвэр Хот” аяны хүрээнд сар бүрийн эхний 7 хоногийн баасан гарагт хийгддэг “Бүх нийтийн гадна талбайн их цэвэрлэгээ”-г зохион байгуулах</p>	<p>“Цэвэр Хот” аяны хүрээнд 5 сарын 01-ний өдөр НЭ-ийн алба тасаг нэгжүүд гадна талбайн их цэвэрлэгээг хийсэн. Их цэвэрлэгээнд нийт 29 алба тасаг нэгж нэгдсэн.</p> 	90%
2	<p>“Нярайд амьдрал бэлэглэе-2026” нярайн 8-р алгоритмын ОУ-н хэмжээний сургалтыг зохион байгуулах</p>	<p>04.30-5.01 өдөр Нярайн тасгийн санаачлагаар жил бүр уламжлал болгон хийгддэг Аймгийн ЗДТГ, Нэгдсэн эмнэлэг, АШУУИС, ХАТТАН, Миллиниум RDS, ICNA олон улсын байгууллагатай хамтран “Нярайд амьдрал бэлэглэе-3” нярайн олон улсын 8-р алгоритмын сургалтанд МУ-ын 21 аймаг, ЭХЭМҮТ болон нийслэлийн амаржих газруудаас нийт 90 төлөөлөл оролцож Австрали, АНУ-ын 4 эмч мэргэжилтэн болон Монголын доктор, профессоруудаас суралцсан 2 өдрийн сургалт зохион байгуулсан.</p> 	100%

<p>3</p>	<p>Нэгдсэн эмнэлэгт мэс заслын тасаг үүсч хөгжсөний түүхт 60 жилийн ойн ажлын хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулах “Цэнхэр кодоор тусламж үзүүлэхэд бидний оролцоо” сэдэвт тэмцээн зохион байгуулах</p>	<p>Нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн албанаас олон нийтийг хамарсан осол, гэмтэл, гамшгийн үеийн эмч, сувилагч болон бусад мэргэжилтнүүдийн багаар үзүүлэх тусламж, үйлчилгээний ур чадвар, хамтын ажиллагаа, бэлэн байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “ЦЭНХЭР КОДООР ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХЭД БИДНИЙ ОРОЛЦОО” сэдэвт амилуулах суурь тусламжийн ур чадварын тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд тасаг, нэгж, албадуудаас бүрдсэн нийт 5 баг оролцож, онолын мэдлэг, амилуулах суурь тусламжийн ур чадвар, багаар ажиллах чадамжаараа өрсөлдөн, сонирхолтой бөгөөд үр өгөөжтэй хэлбэрээр явагдлаа. Тэмцээний дүнгээр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тэргүүн байр–Г.Батболд ахлагчтай “Зүрх асаагчид” баг /Яаралтай тусламж, Мэс засал, Сэтгэц, Сэргээн засах, Цусны салбар төв, Дүрс оношлогоо/ 2. Дэд байр–Т.Бадамцэцэг ахлагчтай “Golden Minute” баг /ЯТТ, Поликлиник I, Гэмтэл, Мэдрэл, Түргэн тусламж/ 3. Гутгаар байр–Г.Ганчимэг ахлагчтай “Цохилох зүрх” баг /МЭЭ, Уламжлалт, Халдварт, Албадууд, Поликлиник II/ <p>Тэмцээний шүүгчээр Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч О.Янжив, Т.Өлзийсайхан болон Нэгдсэн эмнэлгийн захирал Б.Мөнхбат нар ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан.</p>	<p>100%</p>
----------	--	--	-------------





ОУ-ын сувилагчдын өдрийг угтан НЭ-ийн захиргааны албадууд, нийт тасаг нэгжүүдийн төлөөлөл өглөөний “Хүндэтгэлийн улаан хивсны ёслол”-ыг зохион байгуулж сувилагч нараа угтан авсан.



4 ОУ-ын сувилагчдын өдрийг угтан “Хүндэтгэлийн улаан хивсны ёслол”-ыг зохион байгуулах

100%


5	ОУ-ын сувилагчдын өдрийг угтан “Сувилахуйн технологи-2026” зохион байгуулах	Хойшлогдсон.	-
---	---	--------------	---

6	Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг сурталчлах өдөрлөг зохион байгуулах	<p>Нэгдсэн эмнэлгийн Захирлын 2026.04.30 өдөр баталсан Нэгдсэн эмнэлгийн үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээ, албадын үйл ажиллагааг олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг сонсох, мэдээлэл өгөх, эргэн мэдээллэхэд албадын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, хамтын оролцоог сайжруулах зорилго бүхий “Дархан-уул аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг сурталчлах өдөрлөг зохион байгуулах удирдамж”-ийн дагуу үйл ажиллагааг 2026 оны 5 сарын 07-ны өдрөөс 2026 оны 05 сарын 28 өдрийн хооронд баталсан хуваарийн дагуу Поликлиник-1, Поликлиник-2 тасгийн цахим бүртгэлийн хэсэгт зохион байгуулсан.</p> <p>Өдөрлөг: Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр нийт 8 алба хамтарсан байдлаар 8 удаа өдөрлөг зохион байгуулсан.</p> <p>Цахим мэдээлэл: Зохион байгуулагч ХНСХА-ы зүгээс Нэгдсэн эмнэлгийн нийгмийн сүлжээний цахим хаягт нийт 11 бичлэг, рийлийг хийж байршуулсан</p> <div data-bbox="705 590 1276 1005"> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Аймаг, тасгаг нутаг</th> <th>Байрвэл</th> <th>Огноо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Хэнтий аймаг, Сүхбаатар сум</td> <td>Поликлиник 1</td> <td>2026.05.05</td> </tr> <tr> <td>2</td> <td>Дорнод аймаг, Төгрөг сум</td> <td>Поликлиник 1</td> <td>2026.05.06</td> </tr> <tr> <td>3</td> <td>Хэнтий аймаг, Төгрөг сум</td> <td>Поликлиник 1</td> <td>2026.05.06</td> </tr> <tr> <td>4</td> <td>Хэнтий аймаг, Төгрөг сум</td> <td>Поликлиник 1</td> <td>2026.05.07</td> </tr> <tr> <td>5</td> <td>Хэнтий аймаг, Төгрөг сум</td> <td>Поликлиник 1</td> <td>2026.05.12</td> </tr> <tr> <td>6</td> <td>Хэнтий аймаг, Төгрөг сум</td> <td>Поликлиник 1</td> <td>2026.05.13</td> </tr> <tr> <td>7</td> <td>Хэнтий аймаг, Төгрөг сум</td> <td>Поликлиник 1</td> <td>2026.05.14</td> </tr> <tr> <td>8</td> <td>Хэнтий аймаг, Төгрөг сум</td> <td>Поликлиник 1</td> <td>2026.05.19</td> </tr> </tbody> </table> </div>	№	Аймаг, тасгаг нутаг	Байрвэл	Огноо	1	Хэнтий аймаг, Сүхбаатар сум	Поликлиник 1	2026.05.05	2	Дорнод аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.06	3	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.06	4	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.07	5	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.12	6	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.13	7	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.14	8	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.19	100%
№	Аймаг, тасгаг нутаг	Байрвэл	Огноо																																				
1	Хэнтий аймаг, Сүхбаатар сум	Поликлиник 1	2026.05.05																																				
2	Дорнод аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.06																																				
3	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.06																																				
4	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.07																																				
5	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.12																																				
6	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.13																																				
7	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.14																																				
8	Хэнтий аймаг, Төгрөг сум	Поликлиник 1	2026.05.19																																				

7	Эрүүл мэндийн улсын алба (ЭМЯ), ОБЕГ-тай хамтран “Гамшгийн үеийн ЭМ-ийн улсын алба,	Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан холбогдох журам, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль зохион байгуулах тухай” А/115 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/151 дүгээр	100%
---	---	--	------

	<p>Сурталчилгааны улсын албаны удирдлага зохион байгуулалт, хариу арга хэмжээ, харилцан ажиллагаа” сэдэвт гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулах</p>	<p>тушаалын хүрээнд эрүүл мэндийн салбарын “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль” 05 сарын 13-15-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулагдаж Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албаны бүрэлдэхүүнд НЭ-ээс 7 мэргэжилтэн Дархан–Уул аймгийн Эрүүл Мэндийн албаны бүрэлдэхүүнд 3 өдөр танхимын сургалтанд хамрагдсан. НЭ-ийн мэргэжлийн ангийн буюу /Яаралтай тусламж, Цус сэлбэх хөдөлгөөнт бүлэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн бүлэг, Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг, Зоонозын өвчинтэй тэмцэх бүлгийн нийт мэргэжлийн ангийн 5-н бүлгийн 25 мэргэжилтэн, 4 автомашин техник хэрэгсэлтэйгээр бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан.</p>	
8	<p>“Эрүүл гэр бүл” сургалт мэдээлэл зохион байгуулах</p>	<p>НЭМ-ийн мэдлэг түгээх, сургалт суртчилгааны чиглэлээр: Жаргалтай Ээж Төвийн их эмч Э.Ганзултай хамтран “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр рийл бичлэг бэлтгэн хийж НЭ-ийн цахим хуудсаар түгээсэн. Жаргалтай Ээж Төвөөр үйлчлүүлэгчдэд гарын авлага -15 ширхэг тараасан.</p>	95%



9	“Дархлаажуулалт эхэллээ” сэдвээр дархлаажуулалтын ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгаа түгээх	<p>НЭМ-ийн мэдлэг түгээх, сургалт суртчилгааны чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> Гепатитийн 2 сарын аяны хүрээнд “В,С вирусын эсрэг дархлаажуулалт” сэдвээр Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК-ий ажилтнуудад сургалт хийн гарын авлага тараасан. Сургалтанд хамрагдсан 40 ажилтан Дотор, Гэмтэл тасагт хэвтэн эмчлүүлэгчдэд “В,С вирусын эсрэг вакцин” гарын авлага -65 ширхэг тараасан. 	98%
10	“Электрон тамхинаас татгалзая” өдөрлөг, нөлөөллийн ажил зохион байгуулах	<p>НЭМ-ийн мэдлэг түгээх, сургалт суртчилгааны чиглэлээр:</p> <p>“Электрон тамхины хор уршиг” сэдэвт рийл бичлэг бэлтгэн хийж НЭ-ийн цахим хуудсаар түгээсэн.</p> <p>Тамхины хор уршигийн талаар мэдлэг хандлага тодорхойлох судалгааг ЕБС-ийн 14-17 настай 118 хүүхдээс авсан.</p>	90%
11	“Алсын хараа-2050”-ын Хүний хөгжлийн зорилтын /АХЗ.5/ хүрээнд жил бүрийн хүн амын бие бялдрын сорилд НЭ-ийн нийт ажилтнуудыг хамруулах	<ol style="list-style-type: none"> Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил" авах арга аргачлал сургалттыг Сэргээн засах тасгаас зохион байгуулж 12 тасгийн 24 ажилтан хамрагдсан. ББХЧТТСорилд нийт-30 алба, тасаг нэгжийн 390 ажилтан хамрагдсан. Үүнээс Жирэмсэн-5, Сургалтанд явсан-5, Ээлжийн амралттай-11, Өвчтэй-2, Эрүүл мэндийн шалтгаанаар хамрагдахгүй-3 ажилтан байсан. Огт хамрагдаагүй 3 албаны 8 ажилтан /Сувилахуйн алба, Захиргаа, Мэдээлэл технологийн алба/ Үнэлгээний дүнгээр: <ul style="list-style-type: none"> Ø А- үнэлгээтэй-56 ажилтан Ø В- Үнэлгээтэй -102 ажилтан Ø С-Үнэлгээтэй -127 ажилтан Ø D-Үнэлгээтэй-71 ажилтан Ø F-Үнэлгээтэй -24 ажилтан 	90%
12	Асрагч нарын баримжаа олгох цуврал сургалтын дараах ур чадварын үнэлгээ хийх /онол, дадлага/	Асрагч нарын баримжаа олгох сургалтыг 2026 оны 03-р сарын 05-ны өдрөөс 2026 оны 05-р сарын 21-ны хугацаанд онол -8 цаг, дадлага -10 цаг зохион байгуулсан. Сургалтын агуулгад Халдварын сэргийлэлт, хяналт, Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, Хууль эрх зүй, Ёс зүй, Харилцаа, хандлага, Амилуулах суурь тусламжийн хичээл багтсан. Сургалтын явцын үнэлгээг 2 удаа авсан бөгөөд эцсийн үнэлгээний шалгалтыг	100%

онол, дадлага хэлбэрээр ХНСХА-ны дарга Б.Туяасайхан, Халдвар судлаач Ц.Сэлэнгэ, сувилахуйн арга зүйч Т.Дэлгэрцэцэг, сургалтын арга зүйч В.Цэрэндолгор, ахлах сувилагч Д.Мягмар, Ц.Учрал, Б.Элбэгзаяа, Б.Бямбадорж нарын бүрэлдэхүүний хамт үнэлгээг хийсэн. Үнэлгээнд нийт 46 асрагч хамрагдсанаас онолын хичээлийн үнэлгээний дундаж -74%, дадлага сургалтын дундаж үнэлгээ -88,6% буюу 2025 оны баримжаа олгох сургалтын дүнтэй харьцуулахад 2- 9% -ийн ахисан түвшингийн үзүүлэлттэй гарсан.



Нэмж хэрэгжүүлсэн ажил

1	Зэрэг амжилттай хамгаалсан эмнэлгийн мэргэжилтэнд хүндэтгэл үзүүлэх	2026.05.06 өдөр НЭ-ийн удирдлагын зүгээс ахлах зэрэг авсан 3 их эмч, ахлах зэрэгт авсан 7 сувилагч, тэргүүлэх зэрэг авсан 1 сувилагч нийт 11 ажилтанд мэргэжлийн зэргээ амжилттай хамгаалсанд талархал илэрхийлж, цаашдын ажилд амжилт хүсэв.	100%
2	“Эх оронч Монгол” үндэсний хөтөлбөрийн “Монгол эр хүн” зорилтот төслийн нээлтэнд оролцох	2026.05.08 өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эх оронч Монгол” үндэсний хөтөлбөрийн “Монгол эр хүн” зорилтот төслийн нээлтийн үйл ажиллагаанд НЭ-ийн 29 эрэгтэй ажилтан хамрагдсан.	100%
3	“Дархан марафон-2026” гүйлтэд амжилттай оролцох	2026.05.30 өдөр “Дархан марафон-2026” гүйлтийн уралдаанд НЭ-ээс 5км зайд-14 ажилтан, 10км зайд-6 ажилтан амжилттай оролцсон. Нийт -20	100%



2026.05.31 өдөр “Манби Жалбо” уламжлалт анагаах ухааны эмнэлэг, ДУА-ын явган алхалтын холбооноос зохион байгуулсан. “Энэрлээр нэгдэж, эвээр бүтээе” Бурхан Багшийн Их Дүйчин өдөр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан зохион байгуулагдсан “Энх тайвны алхалт”-д Нэгдсэн эмнэлэг нэгдэн 14 ажилтан алхсан.

4 “Энэрлээр нэгдэж, эвээр бүтээе” алхалтанд хамрагдах



100%

2026 оны 05 дугаар сар хариуцсан тасгууд НЭ-ийн алба тасаг нэгжтэй хамтран 12 ажил төлөвлөснөөс 1 ажил хойшлогдож, нэмж 4 ажил хийж нийт 15 ажил хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь 97.4%

Тайлан бичсэн: Хүний нөөц сургалт хөгжлийн алба, Нярайн тасаг, Гэмтлийн тасаг